

**САНГИЙН САЙД, ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРООНЫ
ДАРГЫН ХАМТАРСАН ТУШААЛ**

2012 оны 03 дугаар
сарын 29-ний өдөр

Дугаар 82/51

Улаанбаатар хот

Заавар, загвар шинчлэн
батлах тухай

Нэмэгдсэн өртгийн албан татварын ногдуулалт, төлөлт, буцаан олголтод нягтлан бодох бүртгэлээр тавих хяналтыг сайжруулах зорилгоор Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2-т заасныг үндэслэн ТУШААХ нь:

1. “Нэмэгдсэн өртгийн албан татварын падаан” маягтын загвар, “Нэмэгдсэн өртгийн албан татварын падаан хэрэглэх заавар”-ыг 1 дүгээр хавсралтаар, “Худалдан авалтын бүртгэл”, “Борлуулалтын бүртгэл” маягтын загварыг 2, 3 дугаар хавсралтаар тус тус шинчлэн баталсугай.
2. Шинэчлэгдсэн падааныг татвар төлөгчдөд 2012 оны 5 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн хэрэглүүлэх арга хэмжээ авч, хяналт тавьж ажиллахыг Татварын ерөнхий газар /Б.Баттөмөр/-т үүрэг болгосугай.
3. Энэ тушаал гарсантай холбогдуулан Сангийн сайдын 1999 оны 8 дугаар сарын 3-ны өдрийн 122 дугаар тушаалын 1, 2 дахь заалтыг 2012 оны 5 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн хүчингүй болсонд тооцсугай.



Сангийн сайд, Үндэсний статистикийн
хорооны даргын хамтарсан 2012 оны 82/59
тоот тушаалын 1 дүгээр хавсралт

Маягт НӨАТ-1

Татвар төлөгч нь падааны мэдээллийг
цахим хэлбэрээр бэлтгэж, татварын албанад
сар бурийн 10-ны дотор хүргүүлнэ.

Нэмэгдсэн өртгийн албан татварын падаан

Падааны дугаар:

20..... оны сарын ... өдөр

Борлуулагчийн:

Худалдан авагчийн:

Нэр

Нэр

Регистрийн дугаар

Регистрийн дугаар

Д/д	Бараа, ажил, үйлчилгээний нэр	Код	Хэмжих нэгж	Тоо, хэмжээ	Нэгжийн үнэ, төгрөг	Бүгд үнэ, төгрөг

Бараа, ажил, үйлчилгээний үнэ
Нэмэгдсэн өртгийн албан татвар
Нийт дүн

Хүлээн авсан /...../
(гарын үсэг) (нэр)

Тамга

Хүлээлгэн өгсөн /...../
(гарын үсэг) (нэр)

Тайлбар:

- Нэмэгдсэн өртгийн албан татварын падаан нь 134x192 см-ийн хэмжээтэй, тодорхой нууцлалтай байна.
- Нэмэгдсэн өртгийн албан татварын падааны өнгөн хувь нь цагаан, 2 дахь хувь нь ягаан өнгөтэй байна.
- Нэмэгдсэн өртгийн албан татварын падааны дугаар 10 оронтой, дугаар давхардахгүйгээр, улаан өнгөөр дугаарлагдсан байна.

Нэмэгдсэн өртгийн албан татварын
подааныг хэрэглэх заавар

УХА0216

1. Нэмэгдсэн өртгийн албан татварын подаан (цаашид “подаан” гэх) гэдэг нь борлуулсан бараа, гүйцэтгэсэн ажил, үзүүлсэн үйлчилгээний нэр төрөл, тоо хэмжээ, тэдгээрийн нэгжийн болон нийт үнэ, түүнчлэн нэмэгдсэн өртгийн албан татварын хэмжээг тусгасан, нэгдсэн дугаар бүхий нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримт бичиг юм. Подаан нь нэмэгдсэн өртгийн албан татвар төлөгчөөр бүртгэгдсэн этгээдийн төсөвт төлөх болон бэлтгэн нийлүүлэгчид төлсөн нэмэгдсэн өртгийн албан татварын хасалтыг тодорхойлж, тайлан гаргах үндэслэл болно.

2. Подааныг зөвхөн нэмэгдсэн өртгийн албан татвар төлөгчөөр бүртгэгдсэн этгээд хэрэглэнэ.

3. Нэмэгдсэн өртгийн албан татвар төлөгч (цаашид “татвар төлөгч” гэх)-өөр бүртгэгдсэн аливаа этгээд бараа, ажил, үйлчилгээгээ борлуулахдаа подааныг бичих бөгөөд уг подаанд борлуулсан бараа, ажил, үйлчилгээний нэр төрөл, код (ТЕГ-ын цахим хуудсанд байршуулсан бүтээгдэхүүн, үйлчилгээний нэгдсэн ангиллын 4 орон бүхий код), тоо хэмжээ, тэдгээрийн нэгжийн болон нийт үнийн дүн, нэмэгдсэн өртгийн албан татварын дүн, борлуулагчийн болон худалдан авагчийн бүртгэлийн дугаарыг тусгасан байна. Жишээ нь: Подааны “Бараа, ажил, үйлчилгээний нэр” гэсэн баганад ундаа (2449), талх (2341), цахилгаан түгээлт (8411) гэх мэт борлуулж байгаа бараа, ажил, үйлчилгээг харгалзах кодын хамт тодорхой бичнэ.

4. Подаанд тусгагдах мэдээллийг үнэн зөв, бүрэн бичиж, түүнийг үйлдсэн ажилтан гарын үсгээ зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно. Подааны бүрдэлт, үнэн зөвийг түүнийг олгосон, хүлээн авсан татвар төлөгч хариуцна.

5. Татвар төлөгч нь зөвхөн татварын албанаас олгосон нэгдсэн дугаар бүхий нэмэгдсэн өртгийн албан татварын подааныг хэрэглэнэ.


6. Татвар төлөгч подааныг зөвхөн нэмэгдсэн өртгийн албан татвар төлөгчөөр бүртгэгдсэн этгээдэд олгох бөгөөд подааныг борлуулалт хийсэн тухай бүрдээ бичиж өгнө. Жижиглэнгийн худалдаа эрхлэгчийн хувьд худалдан авагч зөвшөөрсөн тохиолдолд подааныг сард нэг удаа бичиж болно.

7. Подааныг 2 хувь үйлдэх бөгөөд 1-р хувийг борлуулагч нэмэгдсэн өртгийн албан татварын ногдуулалт, төлөлтийг тодорхойлохтой холбогдсон баримтын бүрдэл болгон өөртөө хадгалж, үлдэх хувийг худалдан авагчид өгнө.

8. Бараа, ажил, үйлчилгээг борлуулсан түүнчлэн худалдан авсан татвар төлөгч нь борлуулалтад ногдуулсан болон худалдан авалтын хасалт хийх нэмэгдсэн өртгийн албан татварыг тухайн подаан бичсэн сарын нэмэгдсэн өртгийн албан татварын тайланд тусгана. Харин зээлээр худалдан авалт хийсэн татвар төлөгч нь подааныг төлбөр төлсөн сарын тайланд тусгана.

9. Татвар төлөгч нь подааны мэдээллийг цахим хэлбэрээр бэлтгэж, татварын албанад сар бурийн 10-ны дотор хүргүүлнэ. Нэмэгдсэн өртгийн албан татвар төлөгчөөр бүртгэгдсэн этгээдэд олгосон подааны мэдээллийг бичсэн подаан бүрээр, нэмэгдсэн өртгийн албан татвар төлөгчөөр бүртгэгдээгүй татвар төлөгчид борлуулсан бараа, гүйцэтгэсэн ажил, үзүүлсэн үйлчилгээний орлого, татварын дүнг нэг подаанд бөөн дүнгээр бичиж, мэдээллийн санд оруулна.

* * *



Сангийн сайд, Ундэсний статистикийн
хорооны даргын хамтарсан 2012 оны
тоот тушаалын 3 дугаар хавсралт

Татвар төлөгчийн нэр:

Регистрийн дугаар:

Маягт НӨАТ-3
Татвар төлөгч нь мэдээллийг цахим
хэлбэрээр бэлтгэж, татварын албан
сар бүрийн 10-ны дотор хүргүүлнэ.

Борлуулалтын бүртгэл

20.... оны-р сар

төгрөг

НӨАТ-ын падаан						НӨАТ-аас чөлөөлөгдөх борлуулалтын дүн	“0” хувтай борлуулалтын дүн	НӨАТ-ыг багтаасан борлуулалтын нийт дүн	Үүнээс	
Он	сар	өдөр	Дугаар	Худалдан авагчийн	Регистрийн дугаар				Бараа, ажил, үйлчилгээний үнэ	НӨАТ
1	2	3	4	5	6	7	8	9=(10+11)	10	11

Няглан бодогч
(гарын үсэг)

/...../.
(нэр)

Тайлбар:

1. НӨАТ-аас чөлөөлөгдөх борлуулалт багананд Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн дагуу чөлөөлөгдөх бараа, ажил, үйлчилгээний борлуулалтын орлогыг тусгана.
2. “0” хувтай борлуулалтанд Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн дагуу 0 хувь хэмжээгээр нэмэгдсэн өртгийн албан татвар ногдох бараа, ажил, үйлчилгээний орлого хамаарна.



Сангийн сайд, Ундэсний статистикийн
хорооны даргын хамтарсан 2012 оны 82/57
гоот тушаалын 2 дугаар хавсралт

Маягт НӨАТ-2

Татвар төлөгч нь мэдээллийг цахим
хэлбэрээр бэлтгэж, татварын албанад
сар бүрийн 10-ны дотор хүргүүлнэ.

Худалдан авалтын бүртгэл

20..... оны-р сар

Татвар төлөгчийн нэр:

Регистрийн дугаар:

төгрөг

НӨАТ-ын падаан						НӨАТ-ыг багтаасан худалдан авалтын нийт дүн	Үүнээс				Төлбөр хийсэн							
ОН	САР	ӨДӨР	ДУГААР	БОРЛУУЛАГЧИЙН			ТАТВАР ТӨЛӨГЧӨӨС АВСАН		ИМПОРТООР АВСАН		ОН	САР	ӨДӨР	БАРИМТЫН ДУГААР	НИЙТ ДҮН	ҮҮНЭЭС		
				НЭР	РЕГИСТРИЙН ДУГААР		БАРАА, АЖИЛ, ҮЙЛЧИЛГЭЭ (БАУ)-НИЙ ҮНЭ	НӨАТ	БАУ- НИЙ ҮНЭ	НӨАТ						БАУ-НИЙ ҮНЭ	НӨАТ	
1	2	3	4	5	6	7=(8+9+10+11)	8	9	10	11	12	13	14	15	16=(17+18)	17	18	

Нягтлан бодогч

(гарын үсэг)

/..... /

(нэр)